

Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Амгалан Мөнх-Эрдэнэ
2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх							
1	Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудасны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 3 Хамрагдсан улсын байцаагч - 40	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 2 Хамрагдсан улсын байцаагч - 25	1. Нийслэл, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагуудын эрсдэлийг үнэлж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэсэн. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр: - Сургуулийн өмнөх боловсролын 1309 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийснээс 368 нь бага, 770 нь дунд, 171 нь их эрсдэлтэй; - Ерөнхий боловсролын 836 сургуульд эрсдэлийн үнэлгээ хийснээс 154	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					нь бага, 558 нь дунд, 124 нь их эрсдэлтэй; - Мэргэжлийн болон техникийн боловсролын 72 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийснээс 21 нь бага, 46 нь дунд, 5 нь их эрсдэлтэй үнэлэгдлээ. Мөн энэхүү мэдээллийг үндэслэн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага тус бүрээр тоон үзүүлэлтийн графикийг гарган 2023-2024 оны боловсрол, шинжлэх ухааны салбарын статистик мэдээллийн номонд оруулсан. 2. Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан буюу шилэн хяналтын цахим систем ашиглалтанд орж байгаатай холбогдуулан системд яам, нийслэл, орон нутгийн улсын байцаагч нарт эрх үүсгэн, СӨББ, ЕБС,		
--	--	--	--	--	---	--	--

					Мэргэжлийн болон техникийн боловсрол, их, дээд сургууль, тэдгээрийн дотуур байр, шинжлэх ухааны байгууллагуудыг шалгах шинэчлэгдсэн хяналтын хуудсуудыг угсарч оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд төлөвлөлт, хяналт шалгалтын мэдээллийг оруулах талаар яам, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдыг сургалтад хамруулж, зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлагыг хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		
2	Боловсролын багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгнө.	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 3	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 1	Боловсролын багц хууль шинэчлэгдэн холбогдох дүрэм журам, шинээр болон шинэчлэн батлагдсантай холбогдуулан Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл	6-р сар, 9-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					ажиллагааг шалгах хяналтын хуудас, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдаас санал авч, БШУ-ны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулсан. Хяналтын хуудсуудыг БШУЯ-ны цахим хуудсанд байршуулж, аж ахуйн нэгж, байгууллага татан авч өөрсдийгөө үнэлэх боломжтой болгосон. Хавсралт: 3 файл		гүйцэтгэсэн байдал: 100%
3	Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх,	Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	Шалгалт хийсэн объектын тоо - 16 Зөрчил арилгуулалтын хувь - 55% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 64%	Шалгалт хийсэн объектын тоо - 3 Зөрчил арилгуулалтын хувь - 30% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 35%	Эрсдэлийн үнэлгээгээр их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 11 мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 2024	3-р сар, 4- р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын

	улсын байцаагчдад арга зүйн зөвлөгөө, чиглэл өгөх				онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөн, удирдамжийг хамтран батлуулсан. Удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийх талаар улсын байцаагчдад заавар чиглэл өгсөн. Төлөвлөгөөт шалгалт үргэлжилж байна. Одоогоор 5 байгууллагад шалгалт хийсэн. Хавсралт: 1 файл		үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
4	Хэнтий аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар болон их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийх	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	-	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо - 2 Зөрчил арилгуулалтын хувь - 40% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 55%	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны 03-00/20 дугаар удирдамжийн дагуу ажлын хэсэгт орж ажиллан, Хэнтий аймгийн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын	4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтад Хэнтий аймгийн Өндөрхаан сумын 8-р цэцэрлэг, 5-р сургууль, политехник коллеж, Норовлин, Дадал, Баян-Адарга сумын цэцэрлэг, сургуулиуд хамрагдан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 11 заалт бүхий хугацаатай хамтарсан албан шаардлага өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Хавсралт: 2 файл		
5	МУ-ын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолын дагуу зохион байгуулалтын өөрчлөлт орж нэгдсэн политехник коллежүүдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь	-	Хяналт шалгалт хийсэн объектын тоо - 3 Зөрчил арилгуулалтын хувь - 20%	Тус шалгалт нь Хэнтий аймгийн төлөвлөгөөт шалгалт болон их, дээд сургууль, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулиудад төлөвлөгөөт бус шалгалт хийгдсэнтэй холбогдуулан давхацсан тул 9-11 дүгээр сард хийгдэхээр болсон. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар	5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 0% Нэгжийн даргын үнэлгээ: 60% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					тогтоолын хэрэгжилтийн хүрээнд зохион байгуулалтын өөрчлөлт орж буй мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын зохион байгуулалт бүрэн дуусаагүй байна.		
6	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 100% Зөрчил арилгуулалтын хувь - 100%	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 100% Зөрчил арилгуулалтын хувь - 100%	1. Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03-00/18 дугаар "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу 2 дугаар ажлын хэсгийг ахлан олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий 6 ерөнхий боловсролын сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ. Шалгалтад Сэлбэ, Шинэ үе, Гэгээ, Улаанбаатар элит, Орхон хасу, Жаргалан сургуулиуд хамрагдсан. Шалгалтаар олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг хэдий ч	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					үндэсний хөтөлбөр хэрэгжүүлдэггүй, олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш дутагдалтай, удирдах зөвлөлгүй зэрэг зөрчил дутагдал илэрч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийг арилгах талаар анхааруулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/50 дугаар тушаалын дагуу дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэлт гаргах 1 дүгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, нийслэл, Эрдэнэт, Дархан, Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 39 их дээд сургуульд хяналт шалгалт хийлээ. Шалгалтын дүн, тоон үзүүлэлт, тайланг сургууль бүрээр	
--	--	--	--	--	--	--

					гаргасан. Хавсралт: 3 файл		
3.1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
7	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Дүрэм журмын хүрээнд боловсруулж батлуулсан байна.	Батлуулсан төлөвлөгөөний тоо - 1	Батлуулсан төлөвлөгөөний тоо - 1	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу боловсруулж батлуулсан.	1-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Төлөвлөгөөний биелэлт, тайлан, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь тайлагнасан байна.	Тайлан мэдээ гаргасан тоо - 11	Тайлан мэдээ гаргасан тоо - 6	- Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр хугацаанд нь төрийн мэдээллийн цахим системд тайлагнасан. - Салбарын хяналтын газрын сард хийсэн томоохон ажлын тайлан, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, сарын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тус тус сар бүр гаргасан. Мөн	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр цаг хугацаанд нь төрийн мэдээллийн цахим системд тайлагнан ажиллалаа.		
9	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргасан байна.	ХАСХОМ мэдүүлсэн тоо - 2	ХАСХОМ мэдүүлсэн тоо - 1	Хууль тогтоомжид заасны дагуу төрийн албан хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргаж, 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Хүний нөөцийн мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. Хавсралт: 1 файл	1-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
10	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, үйлдсэн баримт бичгийг ангилан төрөлжүүлж, байгууллагын архивт шилжүүлнэ.	Хууль, дүрэм журмын дагуу хугацаанд нь гаргаж өгсөн байна.	-	Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо - 2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн дагуу Зөрчлийн хэргийн 4 боть баримт бичиг, урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамж, үйлдсэн баримт бичгийг ангилан төрөлжүүлж,	2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн

					хүлээлгэн өгсөн.		байдал: 50%
11	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэх	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 100%	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 100%	- Тайлант хугацаанд 5 албан бичгийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэн, хариуг хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Салбарын хяналтын газраас нийслэл, орон нутгийн Боловсрол, шинжлэх ухааны хяналтын улсын байцаагч нарт зохион байгуулсан сургалтын товч мэдээлэл болон цаашид сургалт зохион байгуулах талаарх мэдээллийг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 2/1661 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. - Төлөвлөгөөт бус удирдамжаар нийт 45 боловсролын сургалтын байгууллагад хяналт шалгалт хийсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
12	Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Гүйцэтгэлийн хувь	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100%	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100%	- Боловсрол, шинжлэх ухааны яамны 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

					байгуулах комиссын нарийн бичгийн даргаар ажиллан, хийх ажлын төлөвлөгөө гаргаж, урилгаар оролцох хүмүүсийн нэрс, зохион байгуулалтын үйл ажиллагаа болон холбогдох гэрээнүүдийг /12 гэрээ/ хийж, арга хэмжээг 2024 оны 02 дугаар сарын 17-ны өдөр амжилттай зохион байгуулсан. - Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу салбарын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэн гаргаж, Бодлогын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт хүргэсэн. 2023 онд төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан газруудад салбарын хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт нийт 66%- тай байгаа ба сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 69%, ерөнхий боловсролын сургуульд 63%,	сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	--	---

					мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 64%, их, дээд сургуулиудад 68%-тай байна. - Төрийн нарийн бичгийн даргын баталсан тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яамны эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллан, яамны ажилтнуудын хүүхдийн судалгааг газар, хэлтсээс судалгаа авч нэгтгэн, шинэчилсэн судалгааг гаргаж өглөө. 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсан "Аз жаргалтай гэр бүл" арга хэмжээг зохион байгуулахад хамтран оролцлоо. - Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу БШУ-ны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, 39 их, дээд сургууль, түүний салбарт гүйцэтгэлийн үзүүлэлтийг шалгаж, сургууль бүрээр		
--	--	--	--	--	--	--	--

					үзүүлэлт, тайланг гаргасан. Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 03-00/18 дугаар удирдамжийн дагуу 2 дугаар ажлын хэсгийг ахлан олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий 6 ерөнхий боловсролын сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг хэдий ч үндэсний хөтөлбөр хэрэгжүүлдэггүй, олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш дутагдалтай, удирдах зөвлөлгүй зэрэг зөрчил дутагдал илэрч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийг арилгах талаар анхааруулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.		
--	--	--	--	--	---	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны болон салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн шинээр болон шинэчлэн батлагдсан дүрэм журмыг уншиж судлах	Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж, судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.	Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна.	Хууль тогтоомжийн уншиж судалсан байна.	- Салбарын чиглэлээр шинээр болон шинэчлэгдэн гарч буй дүрэм журам, шийдвэртэй тухай бүр танилцан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын чиглэлээр батлагдан гарч буй дүрэм журмыг нийслэл, орон нутгийн улсын байцаагч нарт тухай бүр танилцуулан хүргэж, мэдээллийн сан үүсгэсэн. - Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулиуд болон 2 төрлийн стандартыг сайтар судлан хамаарах хяналтын хуудсуудыг шинэчлэн боловсруулж батлуулан, улсын байцаагч нарт хүргэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. - БШУЯамны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

					дэргэдэх ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилогдсонтой холбогдуулан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох дүрэм журмыг уншиж судалж байна.		
2	Мэргэжил, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдана.	Яам болон холбогдох газруудаас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана.	Зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал - 11	Зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал - Тухай бүр	Мэргэжил, боловсролоо дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим дараах сургалтуудад хамрагдсан. 1. Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, амжилттай төгсөж, сертификат гардан авсан. 2. Шилэн хяналтын цахим систем шинэчлэгдэн ашиглагдаж байгаатай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудас угсрах" сургалт, 05 дугаар сарын 30-ны өдөр "Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн хөтлөх, ашиглах, мэдээлэл оруулах талаар сургалтад хамрагдаж, заавар зөвлөгөө авсан. 3. Байгууллагаас зохион байгуулсан Мэдээллийн цаг хөтөлбөрт тухай бүр хамрагдсан.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					Тухайлбал: - 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр "Витамины хэрэглээ" болон багц оношилгооны талаар товч мэдээлэл - Нурагийн ерөнхий эмч С.Цэрэнпагма, - 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал" сэдвээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн ХАБЭА-н сургалт хариуцсан мэргэжилтэн Х.Дарьсүрэн, - Төрийн захиргаа, удирдлагын газраас зохион байгуулсан "Ажилтны сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс, стресс" зэрэг сэдвүүдээр мэдээлэл сонсож, мэдлэгээ дээшлүүлсэн.		
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны талаар сургалтад хамрагдах	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох цахим сургалтад хамрагдах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах талаар мэдлэгтэй болно.	Санхүүгийн мэдлэг дээшилсэн байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн танилцуулга сургалтад, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны талаар сургалтад хамрагдсан.	2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Амгалан Мөнх-Эрдэнэ /...../

.....

Огноо: